



НИЙСЛЭЛИЙН МОНГОЛЫН ЛИБЕРАЛ АРДЧИЛСАН НАМД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 1032
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Нийслэлийн Монголын Либерал Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны

төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Нийслэлийн Монголын Либерал Ардчилсан намаас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн Монголын Либерал Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /...хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



МОНГОЛЫН ЛИБЕРАЛ АРДЧИЛСАН НАМ-аас

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2024 оны сонгуульд дэвшүүлж буй

“Мөрийн Хөтөлбөр”

Нэг. Цар тахлын дараах нийслэл

Хоёр. Амьдрахад таатай нийслэл

Гурав. Солонгосон эдийн засаг

Дөрөв. Тэгш боломжийг хүн бүрт

Тав. Хотдоо үлдэж, сайхан амьдарцгаая.



Улаанбаатар хот
2024 он

Нэг. Цар тахлын дараах Нийслэл

1.1 Цар тахлын үеийн удирдлагад ил тод нээлттэй үнэлгээ хийж, хариуцлага тооцно.

1.1.1 Цар тахлын үеийн удирдлагын үр дүнтэй байдалд үнэлгээ хийж, онцгой үеийн удирдлагын арга зүйг боловсронгуй болгоно.

1.1.2 Цар тахлын үед эрүүл мэндийн салбарт тулгарсан саад бэрхшээлийг үнэлж, шаардлагатай арга хэмжээг авна.


1.2 Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал, ажилгүйдлийг бууруулна.

1.2.1 Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулна.

1.3 Цар тахлаас үүдэлтэй боловсролын доголдлыг залруулна.

1.3.1 Багш нарт зориулсан хөгжлийн дунд хугацааны бодлогыг санаачилж, өөрийгөө хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

1.3.2 Цахим сургалтаас үүдэлтэй сургалтын хоцрогдлыг арилгах шат дараатай арга хэмжээг санаачилж ажиллана.



Хоёр. Амьдрахад таатай Нийслэл

2.1 Гэр хорооллыг орон сууцжуулах, аятай таатай амьдралыг дэмжих үйл явцыг эрчимжүүлнэ.

2.1.1 Ипотекийн зээлийн үйл ажиллагааг хүртээмжтэй болгоно.

2.1.2 Гэр хорооллын дэд бүтцийг амжиргаандаа тохирсон аргаар аятай тухтай, утаагүй, бохирдолгүй амьдрах нөхцөл, боломжуудыг судалж шинээр олон шатлалын стандартыг нутагшуулна.

2.2 Хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.

2.2.1 Хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, залуу эцэг эхчүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.


2.2.2 Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх шинэлэг аргыг судлан нэвтрүүлж, цалин хөлсийн тогтвортой байдлыг хадгалах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3 Ахмадуудын аятай таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

2.3.1 Ахмад насандаа идэвхтэй, эрүүл амьдрахад зориулсан хөтөлбөр санаачилж хэрэгжүүлнэ.

2.4 Залуучуудын хөгжлийг дэмжинэ.

2.4.1 Залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэл зүйн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.



Гурав. Солонгорсон эдийн засгийг хөгжүүлэх

3.1 Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

3.1.1 Нийтийн тээвэр, эрчим хүч, ундны ус, дижитал дэд бүтэц зэрэг иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.

3.1.2 Үер, зуд зэрэг байгалийн гамшгийг даван туулах, учирсан хохирлыг нөхөн сэргээхэд зориулагдсан дэд бүтцийг хөгжүүлнэ.

3.2 Жижиг бизнес эрхлэгчид болон энтрпренеруудыг дэмжих эко систем бүрдүүлнэ.

3.2.1 Шинээр бизнес эрхлэгчдэд зориулсан салбар тус бүрийн чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, төрийн байгууллагаас шинээр үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах шат дамжлагыг хялбаршуулж ажиллана.

3.2.2 Төрийн хүнд суртлыг бууруулж, бизнес эрхлэгчдэд ирэх төрөл бүрийн дарамтыг бууруулна.

3.3 Хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийг бий болгоно.

3.3.1 Мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг шинэ зууны технологи, эдийн засгийн нөхцөл байдалд тохируулж шинэчлэх ажлыг эхлүүлнэ.

3.3.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг ажил олгогчид, үйлдвэрлэгчид, шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, боловсролын шинэчлэлд саналуудыг тусгаж ажиллана.

3.4 Ил тод, хариуцлагатай төсвийн зарцуулалт

3.4.1 Урт хугацааны төсвийн тогтвортой байдлыг дэмжсэн төсвийн бодлого баримталж ажиллана.



Дөрөв. Тэгш боломжийг хүн бүрт

4.1 Боловсролын тэгш боломжийг бүрдүүлнэ.

4.1.1 Улсын сургуулийн сургалтын чанарт анхаарч, чанартай боловсролыг хүүхэд бүрт олгох боломжийг бүрдүүлнэ.

4.1.2 Сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулж, насан туршийн боловсролын суурь мэдлэг олгоход анхаарна.

4.1.3 Боловсролын зээл, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг дэмжих замаар өсөх ирээдүйтэй боловсон хүчнүүдийн боловсрол эзэмших боломжийг дэмжинэ.

4.2 Эдийн засгийн тэгш боломжийг бүрдүүлнэ.

4.2.1 Гарааны бизнес эрхлэгчдийн бий болгосон ажил, үйлчилгээтэй уялдуулсан хөгжүүлэлт, сургалтын тогтолцоог нутагшуулна.

4.3 Нийгмийн шударга ёсыг дэмжинэ.

4.3.1 Эрх нь зөрчигдсөн, маргинал бүлгүүдийн хүний эрхийг сэргээх, хамгаалах тогтолцоог дэмжиж ажиллана.

4.3.2 Хууль тогтоомжуудын хэрэгжилтэд үнэлгээ хийж, хүн нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл зэргээсээ хамаарч эрх нь зөрчигдөхөөс сэргийлж, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд анхаарч ажиллана.



Тав. Хотдоо үлдэж, сайхан амьдарцгаая

5.1 Дээд боловсролын шинэчлэлийг эхлүүлж, эх орондоо чанартай боловсрол эзэмших нөхцлийг бүрдүүлнэ.

5.1.1 Их дээд сургуулийн чанар, чансааг нэмэгдүүлэх үүднээс боловсролын шалгуур үзүүлэлтийг сайжруулах, гадаад хамтын ажиллагааг дэмжиж нийслэлдээ чанартай дээд боловсрол эзэмшдэг байх нөхцлийг бүрдүүлнэ.

5.1.2 Шинжлэх ухааны тэргүүлэх зорилт бүхий төслүүдийг олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хурдтай хөгжүүлэх төвүүдийг байгуулна.

5.2 Хотдоо ажиллах, мэргэжлийн ур чадвараа хөгжүүлдэг байх нөхцлийг бүрдүүлнэ.


5.2.1 Технологи, сэргээгдэх эрчим хүч зэрэг нарийн мэргэжлийн үйлдвэрлэлүүдийг дэмжих замаар, чадварлаг боловсон хүчнүүдээ нийслэлдээ ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

5.2.2 Мэргэжлийн сургалтын чанарыг сайжруулж, хөдөлмөрийн зах зээлийн импорт, экспортын харьцааг нийслэлдээ ээлтэй байлгахад анхаарч ажиллана.

5.3 Амьдралын чанарыг сайжруулах, аятай таатай амьдрах орчныг сайжруулна.

5.3.1 Төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй, хүнд сурталгүй болгох үйл явцыг хурдасгана.

5.3.2 Ажил, хувийн амьдралын тэнцвэрийг хангахад анхаарч, уян хатан ажлын цаг, гэр бүлд ээлтэй амьдралын хэв маягийг бий болгоход төрийн бодлогыг чиглүүлнэ.



A handwritten signature in blue ink, consisting of a long horizontal stroke followed by a loop and a vertical stroke.

A handwritten signature in blue ink, consisting of a series of loops and a vertical stroke.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 № 1037
танай _____-ны № _____-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
МОНГОЛЫН ЛИБЕРАЛ
АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Баянзүрх дүүргийн Монголын Либерал Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны

төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Баянзүрх дүүргийн Монголын Либерал Ардчилсан намаас Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянзүрх дүүргийн Монголын Либерал Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /6...хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Баянзүрх дүүргийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



МОНГОЛЫН ЛИБЕРАЛ АРДЧИЛСАН НАМ-аас

Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2024 оны сонгуульд дэвшүүлж буй

“Мөрийн Хөтөлбөр”


Нэг. Цар тахлын дараах дүүрэг

Хоёр. Амьдрахад таатай дүүрэг

Гурав. Солонгорсон эдийн засаг

Дөрөв. Тэгш боломжийг хүн бүрт


Тав. Хотдоо үлдэж, сайхан амьдарцгаая.



Улаанбаатар хот
2024 он


Нэг. Цар тахлын дараах дүүрэг

- 1.1 Цар тахлын үеийн удирдлагын үр дүнтэй байдалд үнэлгээ хийж, онцгой үеийн удирдлагын арга зүйг боловсронгуй болгоно.
- 1.2 Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулна.
- 1.3 Цахим сургалтаас үүдэлтэй сургалтын хоцрогдлыг арилгах шат дараатай арга хэмжээг санаачилж ажиллана.



Хоёр. Амьдрахад таатай дүүрэг

- 2.1 Гэр хорооллын дэд бүтцийг амжиргаандаа тохирсон аргаар аятай тухтай, утаагүй, бохирдолгүй амьдрах нөхцөл, боломжуудыг судалж шинээр олон шатлалын стандартыг нутагшуулна.
- 2.2 Хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, залуу эцэг эхчүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.
- 2.3 Ахмад насандаа идэвхтэй, эрүүл амьдрахад зориулсан хөтөлбөр санаачилж хэрэгжүүлнэ.
- 2.4 Залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэл зүйн үйлчилгээг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.




A handwritten signature in blue ink, appearing to be "Алст".

A handwritten signature in blue ink, appearing to be "Алст".


Гурав. Солонгорсон эдийн засгийг хөгжүүлэх

- 3.1 Нийтийн тээвэр, эрчим хүч, ундны ус, дижитал дэд бүтэц зэрэг иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 3.2 Төрийн хүнд суртлыг бууруулж, бизнес эрхлэгчдэд ирэх төрөл бүрийн дарамтыг бууруулна.
- 3.3 Мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг шинэ зууны технологи, эдийн засгийн нөхцөл байдалд тохируулж шинэчлэх ажлыг эхлүүлнэ.
- 3.4 Урт хугацааны төсвийн тогтвортой байдлыг дэмжсэн төсвийн бодлого баримталж ажиллана.



Дөрөв. Тэгш боломжийг хүн бүрт

- 4.1 Улсын сургуулийн сургалтын чанарт анхаарч, чанартай боловсролыг хүүхэд бүрт олгох боломжийг бүрдүүлнэ.
- 4.2 Сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулж, насан туршийн боловсролын суурь мэдлэг олгоход анхаарна.
- 4.3 Гарааны бизнес эрхлэгчдийн бий болгосон ажил, үйлчилгээтэй уялдуулсан хөгжүүлэлт, сургалтын тогтолцоог нутагшуулна.
- 4.4 Хууль тогтоомжуудын хэрэгжилтэд үнэлгээ хийж, хүн нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл зэргээсээ хамаарч эрх нь зөрчигдөхөөс сэргийлж, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд анхаарч ажиллана.




A handwritten signature in blue ink, appearing to be "Алст".

A handwritten signature in blue ink, appearing to be "Офф".

Тав. Хотдоо үлдэж, сайхан амьдарцгаая

- 5.1 Шинжлэх ухааны тэргүүлэх зорилт бүхий төслүүдийг олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хурдтай хөгжүүлэх төвүүдийг байгуулна.
- 5.2 Технологи, сэргээгдэх эрчим хүч зэрэг нарийн мэргэжлийн үйлдвэрлэлүүдийг дэмжих замаар, чадварлаг боловсон хүчнүүдээ нийслэлдээ ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 5.3 Төрийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй, хүнд сурталгүй болгох үйл явцыг хурдасгана.
- 5.4 Ажил, хувийн амьдралын тэнцвэрийг хангахад анхаарч, уян хатан ажлын цаг, гэр бүлд ээлтэй амьдралын хэв маягийг бий болгоход төрийн бодлогыг чиглүүлнэ.



A handwritten signature in blue ink, consisting of a stylized, cursive script.

A handwritten signature in blue ink, consisting of a stylized, cursive script.